



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### **АУДИТЫН СЭДЭВ: ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ-ТӨГРӨГИЙН БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ**

**Аудит хийсэн  
үндэслэл,  
бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.

### **ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ-ТӨГРӨГИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

**Аудитын  
тайланг  
хүргүүлсэн  
байгууллага:**

УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Монголбанк, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд тус тус хүргүүлэв.

Улаанбаатар хот  
2023 оны 07 дугаар сар

## Аудитын талаарх ерөнхий мэдээлэл

### Аудитын харилцан хамаарал

Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн. Монголбанк инфляцыг жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилт тавин ажиллаж боловч 2021 оны 8 дугаар сараас эхлэн зорилтот түвшнээс давж, 2022 оны 6 дугаар сард 16.9 хүрсэн байна. Төлбөрийн тэнцлийн алдагдлын тэлэлтээс шалтгаалан валютын орох урсгал саарч, төв банкны зүгээс ханшийн огцом хэлбэлзлээс сэргийлэх зорилгоор 2021 оны сүүлийн хагасаас гадаад валютын интервенцийг нэмэгдүүлснээр гадаад валютын албан нөөц 2022 оны 9 дүгээр сарын эцэст 2.8 тэрбум ам.доллар болж, 2021 оны мөн үеэс 33.2 хувиар буурсан байна. Хэдийгээр жил гаруй хугацаанд төв банк интервенц хийж, ханшийг тогтворжуулахыг оролдож байгаа ч төгрөгийн америк доллартой харьцах ханш 2022 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар суларсан байна.

### Аудитын зорилго, зорилтууд

Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон валютын ханшийн өөрчлөлтийг тогтворжуулах бодлогын үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Монголбанк хуулиар тогтоосон мөнгөний бодлогын зорилгоо биелүүлсэн эсэх;
2. Төсвийн бодлого нь мөнгөний бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, хангах чиглэлд боловсруулан хэрэгжүүлсэн эсэх.

### Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамны 2020-2022 оны мөнгөний болон төсвийн бодлогын үйл ажиллагааны үр дүн, бусад холбогдох нөхцөл байдлын нөлөөлөл /Ковид-19 цар тахал/-ийг хамруулан хийж гүйцэтгэлээ.

### Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл

Монголбанкны удирдлага Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Энэ хуулийн 15.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно” гэж заасныг зөрчин Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020-2022 оны тушаалууд, түүний хэрэгжилтийг гаргаж ирүүлээгүйгээс шалтгаалан Монголбанкны 2020-2022 оны үйл ажиллагаанд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах боломжгүй, аудитын дүгнэлт хязгаарлагдсан.<sup>1</sup>

<sup>1</sup> Хэрвээ Монголбанкны Ерөнхийлөгч хууль зөрчсөн тушаал баталж, хэрэгжүүлсэн нь олон нийтэд ил болж, аудитын дүгнэлтэд материаллаг байдлаар нөлөөлсөн тохиолдолд Үндэсний аудитын газар хариуцлага хүлээхгүй болно.

## БҮЛЭГ 1. МОНГОЛБАНК ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ-ТӨГРӨГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

УИХ-ын тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн “...инфляцыг +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулах...” гол зорилт хэрэгжээгүй байна

УИХ-ын тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг Монголбанк хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаарх гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харууллаа. Үүнд:

### Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, гүйцэтгэл

№	ТМБТБҮЧ <sup>2</sup>	Нийт	Хэрэгжсэн	Хэрэгжилт дутуу	Хэрэгжээгүй	Хойшилсон
1	2020	17	12	1	2	2
2	2021	17	13	-	2	2
3	2022	18	11	3	3	1
	Нийт	52	36	4	7	5

Эх сурвалж: Монголбанк ТМБТБҮЧ-ийн хэрэгжилтийн тайлангууд

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах 2020-2022 оны үндсэн чиглэлийн дараах зорилтуудыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

#### 2020 онд:

- Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх **/Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэх/**
- Санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалт, хяналтын нэгдсэн тогтолцоо бий болгох хэрэгцээ, шаардлагыг судалж, олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчны шинэтгэлийг хэрэгжүүлэх санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

#### 2021 онд:

- Олон улсын шилдэг туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх **/Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэх/**
- Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2021-2023 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна.

#### 2022 онд:


- Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх **/Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэх/**
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх.
- Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна. Инфляцыг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн зарчимд тулгуурлан нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байх зарчмыг баримтална.

<sup>2</sup> Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

## Нийлүүлэлтийн сүлжээний доголдлоос шалтгаалсан үнийн өсөлт инфляцад нөлөөлсөн байна

Монгол Улсын инфляцын жилийн түвшин 2020 оны 01 сарын байдлаар 5.6 хувьтай байсан боловч 2021 оны 8 дугаар сараас эхлэн Монголбанкны зорилтот түвшнээс давж, 2022 оны 6 дугаар сард 16.1 хувьд хүрсэн ба 2022 оны 12 сард 13.2 хувьтай гарсан байна.

Улсын инфляц 2020-2022 он



Эх сурвалж: Монголбанк

2021 оны жилийн инфляцад махнаас бусад дотоодын хүнс 2.3 нэгж хувь, махны үнийн өсөлт 2.2 нэгж хувь, импортын хүнс 1.8 нэгж хувь, шатахуун 2.2 нэгж хувь, хатуу түлшний бүлэг 1.7 нэгж хувийг тус тус бүрдүүлжээ.

Инфляцын түвшин 2021 онд өсөхөд голлон урд хил хаалттай байсан, шатахууны үнийн өсөлт, малын гоц халдварт өвчнөөс шалтгаалсан махны үнийн өсөлт, түлшний модны үнэ 39 хувиар өссөн нь нөлөөлсөн байна

2022 оны жилийн инфляцад хүнсний бус импортын бараа 4.4 нэгж хувь, махнаас бусад хүнсний үнийн өсөлт 3.5 нэгж хувь, үйлчилгээний үнийн өсөлт 1.6 нэгж хувь, дотоодын бараа 1.7 нэгж хувийг тус тус бүрдүүлжээ.

2022 онд өсөхөд тээвэр, логистикийн саатал, гурил, гурилан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт, үйлдвэрлэлийн орц, зардлын өсөлт зэрэг үзүүлэлтүүд голлон нөлөөлсөн байна.

## Мөнгөний бодлогын хорооноос эдийн засаг Ковид-19 цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй, инфляц оны эцэст зорилтот түвшний орчимд тогтворжино гэж төсөөлж бодлогын хүүг аажмаар өсгөх стратеги баримталсан байна

Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлаас томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэх мөнгөний бодлогын хороо нь төрийн мөнгөний бодлогын төсөл, мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох, банкны заавал байлгах нөөцийн хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувь, хэмжээг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй.

Инфляц 2021 оны 3 дугаар улиралд 9.6 хувьтай гарч зорилтот түвшнийг давсан байхад Мөнгөний бодлогын хороо дараах шалтгаанаар бодлогын хүүг нэмэгдүүлээгүй, 6 хувьд хэвээр хадгалах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

Мөнгөний бодлогын хорооны хуралдаан 2021.06.23

- МБХ-ноос эдийн засгийн нөхцөл байдал, учирч болох эрсдэл мөн бодлогын хүүг 6 хувьд хүргэж бууруулсны нөлөө эдийн засагт бүрэн гараагүй байгааг харгалзан үзээд бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах нь зүйтэй гэсэн нэгдсэн байр суурьт хүрсэн байна.

Мөнгөний бодлогын хорооны хуралдаан 2021.09.16


- МБХ-ноос эдийн засгийн нөхцөл байдал, учирч болох эрсдэл зэргийг харгалзан үзээд бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах бодлогын шийдвэрт санал нэгдсэн байна. Түүнчлэн инфляц зорилтот түвшнээс давсан энэ үед Төв банкны зүгээс хариу үйлдэл үзүүлэх нь зүйтэй гэсэн саналыг МБХ-ны гишүүд хэлэлцэж Монголбанкнаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 4 дүгээр улиралд олгох хэмжээг бууруулж 100 тэрбум төгрөгт хүргэх нэгдсэн байр суурьт хүрсэн байна.

Мөнгөний бодлогын хорооны хуралдаан 2021.12.16

- Эдийн засгийн өсөлт эргэн буурсантай холбоотойгоор эрэлтийн шалтгаантай инфляц өмнөх төсөөллөөс буурсан, хөдөлмөрийн зах зээл сэргэж амжаагүй ба иргэдийн тогтвортой орлого бий болоогүй, ирэх онд ипотекийн зээлийн төлөлт үргэлжлэх, цахилгаан дулааны төлбөр нэмэгдэх зэргээс хэрэглээ сэргэхээргүй байгаа тул бодлогын хүүг өсгөх тохиолдолд уналтаас сэргэж буй эдийн засгийн өсөлт эргэн саармагжих, хүлээлтээр дамжин зардлууд өсөх зэрэг эрсдэлтэйг онцолсон байна.

2022 оны 2 дугаар сараас бодлогын хүүг 0.5 хувиар нэмж 6.5 хувьд хүргэхээр шийдвэрлэсэн ба үүнээс хойш нэмэгдүүлсээр 2022 оны эцэст 13 хувьд хүргэсэн боловч инфляц зорилтот түвшнээс давсан байна.

Мөнгөний бодлогын хүү



Эх сурвалж: Мөнгөний бодлогын хорооны хурлын хураангуй тэмдэглэлүүд

**Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгөний 2022 оны эцсийн үлдэгдэл 2020 оноос 17.7 хувиар өссөн байна**

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө 2020 онд 24.5 их наяд төгрөг байсан бол жил дараалан өссөөр 2022 онд 29.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

M2 мөнгөний өсөлтөд 2020 онд төгрөгийн хадгаламж 2,278.7 тэрбум төгрөгөөр, 2021 онд төгрөгийн харилцах 2,200.8 тэрбум төгрөгөөр, 2022 онд гадаад валютын харилцах 2,602.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

## Төв банкны үнэт цаасны 2022 оны эцсийн үлдэгдэл 2020 оноос 34.8 хувиар буурсан байна

Монголбанк 2020-2022 онд мөнгөний захыг хөгжүүлэх зорилгоор хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэрээр ялгаатай 3 төрлийн ТБҮЦ-ыг арилжаалсан байна. Үүнд:

*Төв банкны үнэт цаас (тэрбум төгрөг)*

№	Төв банкны үнэт цаас	2020	2021	2022
1	196 хоногтой	250.0	-	667.1
2	28 хоногтой	7,725.2	8,644.9	5,033.7
<b>Нийт дүн</b>		<b>7,975.2</b>	<b>8,644.9</b>	<b>5,700.8</b>

*Эх сурвалж: Монголбанк*

Төв банкны үнэт цаасны үлдэгдэл 34.8 хувиар буурахад Монголбанкны гадаад валютын интервенцээр цэвэр дүнгээр 6,202.7 тэрбум төгрөгийг татсан, Монголбанкны алт худалдан авалтаар нийлүүлсэн 3,192.1 тэрбум төгрөг, Засгийн газрын төрийн сангийн нэгдсэн дансаар нийлүүлсэн 350.6 тэрбум төгрөг нөлөөлсөн байна.

## Монголбанк урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлж ажилласан байна

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Монголбанкны репо санхүүжилтийн эх үүсвэрээр 2,000.0 тэрбум төгрөг олгохоор шийдвэрлэж гүйцэтгэлээр 1,312.0 тэрбум төгрөг олгосон, эргэн төлөлтийн үлдэгдэл 2023 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 760.1 тэрбум төгрөг байна.

## Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээг УИХ-ын тогтоолд зааснаар бүрдүүлж чадаагүй байна

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар “Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлал батлах тухай” тогтоолын 3.2.3.3-т “Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заажээ.

*Гадаад валютын албан нөөцийн мэдээлэл (сая ам.доллар)*

№	Албан нөөц хөрөнгө	2020		2021		2022	
		Үлдэгдэл	Эзлэх хувь	Үлдэгдэл	Эзлэх хувь	Үлдэгдэл	Эзлэх хувь
1	Гадаад валютаар илэрхийлэгдэх нөөц	3,987.5	87.9	3,662.9	83.9	2,890.4	85.0
2	ОУВС-д байршуулсан хөрөнгө	7.8	0.2	7.6	0.2	7.2	0.2
3	Зээлжих тусгай эрх (ЗТЭ)	46.2	1.0	136.0	3.1	121.1	3.6
4	Мөнгөжсөн алт (үүнд алтны хадгаламж, алтын своп хэлцэл зэрэг орно)	492.7	10.9	559.6	12.8	380.9	11.2
<b>Нийт</b>		<b>4,534.2</b>	<b>100.0</b>	<b>4,366.1</b>	<b>100</b>	<b>3,399.6</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Монголбанк*

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2022 оны эцэст 3,399.6 сая ам.доллар байгаа нь валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын жилийн дундаж гүйцэтгэлээр тооцоход 4.9 сар буюу 21 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд байна.

## Төлбөрийн тэнцлийн алдагдлаас шалтгаалан гадаад валютын албан нөөц буурч байна

Гадаад валютын албан нөөц 2021 онд 3.7% буюу 168.1 сая, 2022 онд 22.1% буюу 966.5 сая ам.доллараар тус тус буурсан нь төлбөрийн тэнцэл харгалзан 221.6 сая болон 727.3 сая ам.долларын алдагдалтай гарснаас шалтгаалсан байна.

### Төлбөрийн тэнцлийн хураангуй (сая ам.доллар)

№	Дансны нэр	2020	2021	2022
1	<b>УРСГАЛ ДАНС</b>	(674.6)	(2,108.4)	(2,303.5)
	Бараа	1,755.6	1,369.6	1,232.5
	Үйлчилгээ	(1,450.2)	(1,675.4)	(2,355.0)
	Орлого /анхдагч, хоёрдогч/	(980.0)	(1,802.7)	(1,181.0)
2	<b>ХӨРӨНГИЙН ДАНС</b>	102.8	114.0	154.2
3	<b>САНХҮҮГИЙН ДАНС</b>	1,504.3	1,982.2	1,644.1
	Шууд хөрөнгө оруулалт	1,693.2	2,060.0	2,428.4
	Багцын хөрөнгө оруулалт	(563.3)	(24.9)	(445.1)
	Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	5.7	7.6	11.4
	Бусад хөрөнгө оруулалт	368.7	(60.4)	(350.6)
4	<b>Алдаа болон орхигдуулга</b>	(145.6)	(209.4)	(222.1)
5	<b>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</b>	<b>786.9</b>	<b>(221.6)</b>	<b>(727.3)</b>

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл 2020-2022 онд 1.2-1.7 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Харин үйлчилгээний гадаад худалдааны алдагдал жил бүр нэмэгдэж, 2022 онд өмнөх оноос 41%-иар өсөж 2,355.0 сая ам.долларт хүрсэн нь төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлжээ.

### Алт, үнэт металл худалдан авсан байдал

№	Огноо	Бохир жин /тонн/	Цэвэр жин /тонн/	1 грамм алтны дундаж үнэ /мян.төг/	Монголбанкны төлсөн дүн /тэрбум төг/
1	2020	23.6	17.6	157.8	2,902.0
2	2021	20.8	17.2	164.5	2,869.7
3	2022	22.9	15.8	186.1	2,967.5
4	<b>Нийт</b>	<b>67.3</b>	<b>50.6</b>	-	<b>8,739.2</b>

Эх сурвалж: Монголбанк


Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 03/3/А-5 дугаар хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт 7,859.6 сая, бусад арилжаагаар 922.1 сая, нийт 8,781.7 сая ам.долларыг худалдан авсан байна.

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх зорилгоор цэвэр дүнгээр 2020-2022 онд нийт 3,549.6 сая, гадаад валютын дуудлага худалдаагаар дамжуулан 12,110.3 сая, нийт 15,659.9 сая ам.долларыг валютын захад нийлүүлсэн байна.

Хэдийгээр Монголбанкнаас валютын зах зээлд төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх зорилгоор интервенцийг хийсэн боловч төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш 2020-2022 онд 2,734.3 төгрөгөөс 3,444.6 хүрч өссөн буюу төгрөг ам.долларын эсрэг 20.5 хувиар суларсан байна.



## Төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш



Эх сурвалж: Монголбанкны мэдээлэл /2020-2022 он/

### Монголбанкны хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгасан үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах, ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх гэсэн заалтуудыг нэг утгаар ойлгогдох байдлаар хуульчлах шаардлагатай байна.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж Монголбанкны Ерөнхийлөгч болон Мөнгөний бодлогын хорооны чиг үүрэг, хариуцах ажил үүргийг тодорхой тусгах шаардлагатай байна.

Монголбанкны Дотоод аудит нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтын стандартад шилжиж байгаа учраас ГВАН-д дүгнэлт гаргаагүй байна. Иймд дээрх журмыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 2. ТӨСВИЙН БОДЛОГО НЬ ТӨГРӨГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ОРОН ЗАЙГ БАГАСГАЖ БАЙНА

### Төсвийн тусгай шаардлагуудад өөрчлөлт оруулах замаар төсвийн алдагдал, өрийн дээд хязгаарыг нэмэгдүүлж байна

Төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагын хүрээнд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий **60 хувиас хэтрэхгүй** байх” тусгай шаардлагыг тусгасан боловч 2016 он, 2021 онд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ДНБ-ий **70 хувиас хэтрэхгүй** байхаар тусган өрийн хязгаарыг нэмэгдүүлсэн байна.

Мөн уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний **2 хувиас илүүгүй** алдагдалтай, эсхүл ашигтай байх”-аар хуульчилсан боловч уг заалтад 2017, 2021 онуудад нэмэлт өөрчлөлт оруулж төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ий **12.5 хувиас**, 2021 онд **8.8 хувиас**, 2022 онд **5.1 хувиас** тус тус хэтрэхгүй байхаар тусгасан байна.

Монгол улсын жилийн төсвийг боловсруулж батлах, тодотгол хийхдээ төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх бус, эсрэгээрээ өргөн мэдүүлсэн төсвийн төсөлдөө тохируулан төсвийн тусгай




шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд удаа дараа өөрчлөлт оруулж төсвийн алдагдал, өрийн хязгаарыг нэмэгдүүлж байжээ.

### Төсвийн зарлагын тэлэлт нь импортоор дамжин төлбөрийн тэнцэлд нөлөөлж байна

Засгийн газрын үнэт цаас болон зээлээр 9,335.4 тэрбум, тогтворжуулалтын сангаас 1,514.2 тэрбум, бусад эх үүсвэрээс 75.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийг 2020-2022 онд нийтдээ 10,925.5 тэрбум төгрөгийн алдагдалтайгаар баталжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны гүйцэтгэл, 2020-2022 оны төсөв (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн зарлага жил бүр өсөхөд татаас ба урсгал шилжүүлгийн зардал 2020 онтой харьцуулахад 2022 онд 1.8 дахин, хөрөнгө оруулалтын зардал 1.3 дахин нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын болон татаас, урсгал шилжүүлгийн зардал дийлэнх хувийг эзэлж байгаа төсвийн зарлагын тэлэлт нь импортыг дэмжиж, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлсөн байна.

### Засгийн газрын нийт өрийн дийлэнх хувийг гадаад өр эзэлж байгаа нь гадаад валютын ханшийн эрсдэлийг дагуулж байна

Засгийн газрын өр нэрлэсэн үнээр 2022 оны эцэст 31,965.8 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий 60.5 хувьтай тэнцэж байна.

. Засгийн газрын өр (нэрлэсэн үнээр, тэрбум төгрөг)

№	Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	2020.12.31	2021.12.31	2022.12.31
1	ДНБ (оны үнээр)	37,453.3	43,018.6	52,867.4
2	Засгийн газрын нийт өр (нэрлэсэн үнээр)	27,898.6	26,918.2	31,965.8
3	Засгийн газрын өр, ДНБ-ий харьцаа	74.5%	62.6%	60.5%

Эх сурвалж: УАГ Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан


Засгийн газрын нийт өрийн дийлэнх буюу 95.3 хувийг гадаад валютаар эргэн төлөгдөх гадаад зээл, өрийн баталгаа, үнэт цаасны өр эзэлж байна.

Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь Олон улсын валютын сангийн өрийн тогтвортой байдлын шинжилгээний аргачлалд тусгагдсан анхаарах дээд түвшин 60.0 хувиас өндөр байгаа нь гадаад валютын ханшийн эрсдэл ихтэй байгааг харуулж байна.

## Экспортыг төрөлжүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай байна

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 онд 786.9 сая ам.долларын ашигтай, 2021 онд 221.6 сая, 2022 онд 727.2 сая ам.долларын алдагдалтай гарчээ.

Төлбөрийн тэнцлийн ашиг, алдагдал (сая доллар)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Урсгал дансны бүтцийг авч үзэхэд бараа бүтээгдэхүүний худалдаа ашигтай гарч байгаа боловч үйлчилгээний данс алдагдалтай байна.

Үйлчилгээний данс 2022 онд алдагдалтай гарахад бизнесийн зөвлөх, техникийн болон худалдааны үйлчилгээ 486.6 сая, аялал жуулчлал 745.1 сая, зорчигч, ачаа тээврийн үйлчилгээ 763.0 сая ам.долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн бөгөөд алдагдлын хэмжээ 2020 оноос 1.4-3.6 дахин өсжээ.


Бараа бүтээгдэхүүний бүлгийн ангиллаар уул уурхайн түүхий эд, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн худалдаа ашигтай байгаа бөгөөд 2022 онд нийт 12,540.4 сая ам.долларын бүтээгдэхүүн экспортод гаргасны 84.1 хувийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Харин тээврийн хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийн болон төмөрлөг, чулуун, хуванцар бүтээгдэхүүн худалдаа ихээхэн алдагдалтай байгаа бөгөөд 2022 онд импортоор худалдан авсан нийт 8,704.4 сая ам.долларын бараа бүтээгдэхүүн 19.5 хувийг тээврийн хэрэгсэл, 14.5 хувийг цахилгаан хэрэгсэл, 9 хувийг хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт эзэлж байна. Экспортыг төрөлжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай байна.

## Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг төрөлжүүлж нэмэгдүүлэх шаардлагатай байна

Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 2019 онд 3,130.8 сая, 2020 онд 2,560.3 сая, 2021 онд 2,713.7 сая, 2022 онд 3,417.8 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж гадаад санхүүжилтийн 20 орчим хувийг бүрдүүлжээ.


ГШХО-ын орох урсгал, ДНБ (сая ам.доллар), ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгалыг гадаад валютын албан нөөцтэй харьцуулахад 2020 онд 56.5 хувь, 2021 онд 62.2 хувьтай тэнцэх, 2022 онд валютын нөөцийн хэмжээтэй дүйцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн, нийт хөрөнгө оруулалтын 75 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт хийгдсэн байна.

ГШХО-ын бүтэц, салбараар (Эзлэх хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих эрхзүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах шаардлагатай байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй, төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш 2020-2022 онд 20.5 хувиар суларсан байна.
2. УИХ-ын тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн “...инфляцыг +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулах...” гол зорилт хэрэгжээгүй байна.
3. Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 6 хувиас 13 хувь хүртэл аажмаар нэмэгдүүлсэн боловч Ковид-19 цар тахлын нөлөөгөөрх нийлүүлэлтийн үнийн өсөлтөөс шалтгаалан инфляц зорилтот түвшнээс давсан байна.
4. Монголбанк инфляцын төсөөллийг “*Инфляц Төв банкны зорилтот түвшний орчимд тогтворжих хандлага хэвээр байгаа*” гэж төлөвлөж байсан боловч бодит гүйцэтгэлээр зөрсөн байна.
5. Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2022 оны оны эцэст 3,399.6 сая ам.доллар буюу импортын 4.9 сарын хэмжээг хангахуйц байгаа бөгөөд энэ нь УИХ-ын 2010 оны “Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлал батлах тухай” 48 дугаар тогтоолын 3.2.3.3-т “Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заасан хэмжээнд хүрээгүй байна.
6. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах, ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх гэсэн заалтууд хоёрдмол утгатай, Мөнгөний бодлогын хорооны бодлогын шийдвэрт хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтгүй байна.
7. Төсвийн тусгай шаардлагуудад өөрчлөлт оруулах замаар төсвийн алдагдал, өрийн дээд хязгаарыг нэмэгдүүлж байгаа нь валютын ханшийн эрсдэлийг дагуулж, гадаад валютын албан нөөц буурахад нөлөөлжээ.
8. Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх замаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулах шаардлагатай байна.

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

**Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт:**

- Экспортыг төрөлжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг төрийн бодлогоор дэмжих;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

**Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхланд:**

- Төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлагуудыг баримталж, төсвийн алдагдлыг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Өрийн менежментийг сайжруулж Засгийн газрын гадаад өрийг үе шаттайгаар бууруулах.

**Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд:**

- Монголбанкны хуулиар хүлээсэн зорилт, чиг үүрэгтэй холбоотой эрхзүйн зохицуулалтын талаар Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;
- Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнд хүргэж ажиллах;
- Инфляцын төсөөллийг сүүлийн үеийн дэвшилтэт арга аргачлалыг ашиглан боловсруулах;
- Гадаад валют, алтны нөөцийг импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд хүргэж, нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх.